



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2016 оны 08 сарын 15 өдөр

Дугаар 93

Эрдэнэт

Санал дэмжих тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Боловсролын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ :

1. "Эрдэнэт үйлдвэр" ХХК-ийн харъяанд ажиллаж байгаа Ерөнхий боловсролын 19 дүгээр сургууль, орос хэлний сургалттай 12 дугаар цэцэрлэгийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн орон нутагт шилжүүлэн авах тухай аймгийн Засаг даргын саналыг дэмжсүгэй.

2. Ерөнхий боловсролын 19 дүгээр сургууль, орос хэлний сургалттай 12 дугаар цэцэрлэгийг орон нутгийн өмчид шилжиж байгаатай холбогдуулан сургууль цэцэрлэгийн урсгал зардал болон холбогдох зардлыг улсын төсөвт суулгуулах арга хэмжээ авахыг аймгийн Засаг дарга /Д.Батлут/-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ПҮРЭВЛХАГВА